



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/05

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 03/2993 дугаар албан бичгийн дагуу Заамар сумын нутагт бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоор гэрээ байгуулсан “Зэумар замбала” нөхөрлөлийн үйл ажиллагаа, Улсын ахлах байцаагчийн хамтарсан албан шаардлагын хэрэгжилт, иргэд, нөхөрлөлөөс ирүүлсэн өргөдөл, гомдолд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Даш-Яйчил (Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүд:

Н.Жанлуусүрэн (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн байгаль орчин, уул уурхай хариуцсан мэргэжилтэн)

Г.Ганбаяр (Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

У.Содбаяр (Заамар сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга, Цагдаагийн хошууч)

Г.Тэмүүжин (Төв аймгийн Цагдаагийн газрын Заамар сумын сум дундын цагдаагийн хэлтсийн Экологийн асуудал хариуцсан эрүүгийн байцаагч, цагдаагийн Ахлах дэслэгч)

А.Төгс-Амьдрал (Төв аймгийн тагнуулын хэлтсийн ажилтан, дэслэгч)

М.Цогжавхаа (Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын Газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Т.Мөнхжаргал (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн Геологи, уул уурхай, газрын тос,
хийн хяналтын Улсын байцаагч)

Г.Билгүүн (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн Геологи, уул уурхай, газрын тос,
хийн хяналтын Улсын байцаагч)

Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга:
А.Доржпүрэв (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

2.Хяналт шалгалт хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Хяналт шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн дотор зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг газар дээр нь судлан үзэж хууль тогтоомжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч 2024 оны 01 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Засаг даргад танилцуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 03/2993 дугаартай албан бичигт хариу хүргүүлэхийг ажлын хэсэг (Ж.Даш-Яйчил)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН
ХЭСГИЙН УДИРДАМЖ

2024.01.05

Зуунмод сум

Нэг:Зорилго.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнгийн 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 03/2993 дугаар албан бичгийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны багц хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, норм, стандарт, Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Улсын ахлах байцаагчийн хамтарсан 06/00-06/009-005 дугаартай албан шаардлагын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, хэлбэр:

Төлөвлөгөөт бус шалгалт

Гурав. Шалгалтын арга:

Хяналт шалгалтын объектод үзлэг хийх, баримт бичгийг хянан үзэх, хяналт шалгалтын үйл явц, илэрсэн зөрчил дутагдал, үр дүнг гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийх зэрэг боломжит аргаар баримтжуулж хийнэ.

Дөрөв. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах хүн хуулийн этгээд, объектын нэр:

Төв аймгийн Заамар сумын нутагт бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоор гэрээ байгуулсан “Зэумар замбала” нөхөрлөл

Тав. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч:

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Я.Даш-Яйчил ахалж, Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Доржпүрэв, Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Т.Мөнхжаргал, Г.Билгүүн, Төв аймгийн Цагдаагийн газрын Заамар сумын сум дундын цагдаагийн хэлтсийн Экологийн асуудал хариуцсан эрүүгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Тэмүүжин, Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Г.Ганбаяр, Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтыг хэлтсийн Байгаль орчин, уул уурхай хариуцсан мэргэжилтэн Н.Жанлуусүрэн, Төв аймгийн тангуулын хэлтсийн ажилтан, дэслэгч А.Төгс-Амьдрал, Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын Газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн М.Цогжавхаа нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа:

Шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр хийж гүйцэтгэнэ.

Долоо. Хяналт шалгалт хийх чиглэл, хамрах хүрээ:

1. “Зэумар замбала” нөхөрлөлийн холбогдох хууль тогтоомж, дүрэм, норм, стандарт, Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”,-ын хэрэгжилтийг шалгах.
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Улсын ахлах байцаагчийн хамтарсан 06/00-06/009-005 дугаартай албан шаардлагын хэрэгжилтийг шалгах.
3. “Зэумар замбала” нөхөрлөлтэй холбоотой иргэд, нөхөрлөлүүдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шалгах.

Найм: Маршрут.

Зуунмод сумаас Заамар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Зэумар замбала нөхөрлөлийн гэрээ байгуулсан талбайруу явж ирэх 700 км.

Арав: Дүн мэдээ гаргах тайлагнах.

Ажлын хэсэг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ, цаашид авч хэрэгжүүлэх ажлын санал дүгнэлтээ боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 03/2993 дугаартай албан бичигт хариу хүргүүлж ажиллана.

Удирдамж боловсруулсан:

Геологи, уул уурхай, газрын тос, хийн
хяналтын улсын байцаагч



Г.Билгүүн